



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2015 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 47


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Эрүүл мэндийн сайдын 2011 оны “Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээ, эмчилгээ, оношлогооны журам батлах тухай” 444 дугаар тушаалын дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд Сэргээн засах, физик эмчилгээ үзүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Сэргээн засах Физик эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг нэгдүгээр хавсралтаар, Сэргээн засах Физик эмчилгээний тусламж үйлчилгээний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, Сэргээн засах Физик эмчилгээний удирдамжуудыг гуравдугаар хавсралтаар, Сэргээн засах Физик эмчилгээний тасгийн аппарат, төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрмийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Уг журмыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллахыг Сэргээн засах Физик эмчилгээний тасгийн эрхлэгч /Н.Эрдэнэтуул/-д даалгасугай.
3. Сэргээн засах Физик эмчилгээний тусламж, үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

00153